



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/298

Булган сум

**Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын үйл ажиллагаа, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрэнд явуулын пост худалдан авахад 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Гүйцэтгэгчээр иргэн Х.Энхбилиг (ЧП81100116)-ийг сонгож, гэрээ шууд байгуулан, гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, чанарын шаардлага хангасан барааг хүлээн авч ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Гэрээнд заагдсан барааг холбогдох хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд чанартай нийлүүлэхийг (Х.Энхбилиг)-т үүрэг болгосугай.

4. Дээрх хөрөнгийг Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

